

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оныдугаар
сарын ...-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 1/326 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Багануур дүүргийн төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Багануур дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газрын дарга (Б.Эрдэнэбулган)-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 545, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 176 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.....дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Нийслэлийн Багануур дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт	төг/м³	3,640.0
		Хэмжүүрээр халаалт	төг/ГЖ	56,161.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан	төг/ГЖ	56,191.0

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.....дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН
АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Нийслэлийн Багануур дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт	төг/м ³	2,528.0
		Хэмжүүрээр халаалт	төг/ГЖ	40,404.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан	төг/ГЖ	29,234.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна)	Талбайгаар	төг/м ²	1,200.0
		Хэмжүүрээр	төг/ГЖ	14,495.0
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд	төг/хүн	5,264.0
		Халаалтын бус улиралд	төг/хүн	7,368.0
		Усны зарцуулалтаар	төг/м ³	2,716.0
4	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх	төг/сар	5,491.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай өрх	төг/сар	9,152.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх	төг/сар	18,304.0